



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 4/56

Модот

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/165 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээний бүх үхэр, гахайг хамруулан 2024 оны 05 дугаар сарын 25-ноос 25 хоногийн хугацаанд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд шуурхай зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалт хийх ажлыг малчидад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэн мал сүргээ бэлэн байлгах, урьдчилан сэргийлэх тарилганд ажиллах хүн хүч машин техник шатах тослох материаллын бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлс хийсэн малчид мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн этгээдэд хуулийн дагуу арга хэмжээ тооцож ажиллах, дархлаажуулалтанд шаардлагатай вакцин татан авах, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлд хяналт хийн ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (П.Ганчимэг)- т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахын Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЗОЛЖАРГАЛ

Сумын Засаг даргын 20²⁴ оны
...~~05~~ дугаар ...~~27~~ ны өдрийн
...~~4/38~~ дугаар захирамжийн
хавсралт

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамрагдах мал,
тарилгын хуваарь

№	Аж ахуйн нэр	Хамрагдвал зохих малын тоо		Бүгд	Шаардагдах вакцин\тун\	
		Үхэр	гахай		Тун	мл
1	Дэрст хайрхан МЭҮН	11368	32	11400	11400	22800
2	Үржих баян мандал МЭҮН	3200		3200	3200	6400
3	Цэнхэр бэлчир МЭҮН	3200		3200	3200	6400
	Бүгд	17800	32	17800	17800	35600

0000